



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар АБЦ9

Булган сум

### “Төрийн албаны сэргэлт” болон “Цахим ур чадвар” сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоол, Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Төрийн албаны сэргэлт” болон “Цахим ур чадвар” олгох Төрийн албан хаагчдыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг зохион байгуулсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах 4,198,000 (дөрвөн сая нэг зуун ерэн найман мянга) төгрөгийг аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

